

## ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

/Хугацаа: 2017.05.15-2017.05.25/

### НЭГ. УРАЛДААНЫ ЗОРИЛГО:

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан ББСБ-уудын үйл ажиллагааг хүүхэд өөрийн үзэл бодлоор чөлөөтэй, бүтээлч байдлаар илэрхийлэхийг дэмжин, улмаар тэдний дотоод ертөнц, авъяас чадварыг нээн илрүүлэхэд ошино.

### ХОЁР. УРАЛДААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

- МББСБХолбооны гишүүн ББСБ-ын нийт ажиллагсдын 4-12 насны хүүхдүүд

### ГУРАВ. УРАЛДААНЫ СЭДЭВ:

- “Мөнгө – Миний нүдээр”

*Жич:* Уралдаанд оролцож буй ББСБ-ын ажилтны хүүхэд, ач нар тухайн ажилтны хийдэг ажлыг өөрийн үзэл бодлоор чөлөөтэй илэрхийлнэ.

### ДӨРӨВ. УРАЛДААНЫ ЖУРАМ:

Уралдаанд оролцогчдыг насны бүлгээр 3 ангилна. Үүнд:

- Насны ангилал: 4-6 нас
- Насны ангилал: 7-9 нас
- Насны ангилал: 10-12 нас

### ТАВ. УРАЛДААНЫ БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

1. Сонгосон сэдвийн агуулгад нийцсэн байна
2. Гар зургийг АЗ-ын хэмжээтэй **ватүм** цагаан цаасан дээр бүх төрлийн будаг, харандааг ашиглан зурна.
3. Уралдаанд оролцож буй бүтээлийг зөвхөн өөрийн уран сэтгэмжээр зурсан байна
4. Уралдаанд оролцож буй бүтээлийг 2017 оноос хойш зурсан байна
5. Уралдаанд оролцож буй бүтээлээр өмнө нь өөр төрлийн уралдаанд оролцоогүй байна
6. Уралдаанд оролцож буй бүтээлийн ард талын баруун доод буланд дараах мэдээллүүдийг цэвэр, гаргацтай бичсэн байна
  - Бүтээлийн нэр
  - Оролцогчийн овог, нэр
  - Аав/Ээж/Өвөө/Эмээ-ийн нэр болон ажилладаг ББСБ-ын нэр
  - Төрсөн он, сар, өдөр
  - Харилцах утас, гэрийн хаяг

### **ЗУРГАА: БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ:**

Бүтээлийг 2017.05.15-2017.05.25-ны оройн 18:00 цаг хүртэл МББСБХолбооны байранд эх хувиар хүлээн авна.

Холбогдох утас: 9999-8770

Хугацаанаас хоцорсон бүтээлийг хүлээн авахгүй бөгөөд оролцож буй бүтээлийг буцаан олгохгүй.

### **ДОЛОО: ШАЛГАРУУЛАЛТ:**

Шалгаруулалт 2 төрлийн онооны нийлбэрээс бүтнэ.

- Ерөнхий шүүгчдийн оноо /60 хувь/
- Үзэгчдийн оноо /40 хувь/

Уралдааны бүтээлээр 2017.05.30 –ний өдөр 15.00 цагаас Анкоре ресторанд үзэсгэлэн гарган, ялагчдыг тодруулна. Бүтээлээ ирүүлсэн хүүхэд бүрт батламж, бэлэг гардуулна.

### **НАЙМ: ШАГНАЛЫН САН:**

#### **НЭГДҮГЭЭР БАЙР:**

4-6 нас	1 хүүхэд	Өргөмжлөл, 50,000 төгрөг, бэлэг
7-9 нас	1 хүүхэд	Өргөмжлөл, 50,000 төгрөг, бэлэг
10-12 нас	1 хүүхэд	Өргөмжлөл, 50,000 төгрөг, бэлэг

**ОРОЛЦСОН ХҮҮХЭД БҮРТ БЭЛЭГ, БАТЛАМЖ ОЛГОНО.**